

ГАРЧИГ

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
II. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	7
V. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД	9
VI. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
VII. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
IX. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	13
X. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	14

ТӨЛӨВЛӨГӨӨ ДЭХ ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжиж буй байршил /*Google earth/	3
Зураг 2. Үйлдвэр, агуулахын бүсийн сансрын зураг /*Google Earth-2024/	3

ТӨЛӨВЛӨГӨӨ ДЭХ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн хэрэгжиж буй талбайн байр зүйн солбицол	2
Хүснэгт 3. Тухайн жилийн БОМТ нийт зардлын нэгтгэл	6

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн хэрэгжүүлэгч:

“MERA”ХХК

Төслийн нэр:

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”

Улсын бүртгэлийн дугаар: 9011108011

Регистрийн дугаар: 2619687

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Монгол улс-210644, Улаанбаатар хот | Сити Тауэр /17 давхарт/, Чингис хааны нэрэмжит талбай 1, 8-р хороо Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс, 14200

Утас: 75 55 66 77 **Факс:** 11 319276 |


Төслийн байршил.

Налайх дүүргийн Засаг Даргын 2022 оны 08-р сарын 17-ны өдрийн А/228 тоот шийдвэрийг үндэслэн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 1261610685 нэгж талбарын дугаар бүхий 158054 м² газрыг (15.8 га) үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр гэрчилгээ олгогдсон. ҮАЦ нь Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос зүүн урагш 45км, Налайх дүүргийн төвөөс баруун урагш 2.4 км зайтай байрладаг.

Хүснэгт 1. Төслийн хэрэгжиж буй талбайн байр зүйн солбицол

#	X	Y
1	47° 44.727'N	107° 15.022'E
2	47° 44.726'N	107° 14.813'E
3	47° 44.754'N	107° 14.769'E
4	47° 44.870'N	107° 14.767'E
5	47° 44.871'N	107° 14.890'E
6	47° 44.925'N	107° 14.890'E
7	47° 44.929'N	107° 15.117'E
8	47° 44.668'N	107° 15.118'E
9	47° 44.669'N	107° 15.022'E

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн шаардлагын дагуу үйлдвэр нь байнгын их хөдөлгөөнтэй зам, улсын чанартай объект, хүн ам бүхий сууринаас нэг километрийн зайтай байх, бэлэн бүтээгдэхүүн болон түүхий эдээ төмөр зам болон авто замаар тээвэрлэх боломжтой, өндөр хүчдэлийн цахилгаан шугамд холбогдох боломжоор хангагдсан байх шаардлагыг үндэслэн үйлдвэрийн байрлалыг Налайх-Чойр чиглэлийн автозамаас 950 метр, Улаанбаатар-Замын үүд чиглэлийн төмөр замаас 15 км зайд, цэргийн локаторын ангиас 930 метр алслагдсан зайд сонгон байгуулсан.



*Зураг 1. Төсөл хэрэгжиж буй байршил /*Google earth/*



*Зураг 2. Үйлдвэр, агуулахын бүсийн сансрын зураг /*Google Earth-2024/*

Төслийн ач холбогдол:

Эмульсийн тэсрэх бодисын гол түүхий эдийн нэг болох эмульгатор бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулснаар импортын бүтээгдэхүүнийг орлох, тэсрэх бодисын чанар, тэсэлгээний эцсийн үр дүнг сайжруулах, оновчлоход чухал ач холбогдолтой юм.

Эмульгаторыг бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэснээр гадаадын ханган нийлүүлэгчдийн хязгаарлагдмал сонголт, нэг дор их хэмжээгээр худалдан авахаас өөр сонголтгүй байгаа хараат байдлыг бууруулж, чанартай шингэн эмульсийн тэсрэх бодисын найдвартай, тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход томоохон хувь нэмрээ оруулна. Мөн эмульсийн тэсрэх бодист ашиглагдах эмульсийн тэсрэх бодисын хольцын (эмульгатор) үйлдвэрийн технологийг нутагшуулж, энэ чиглэлээр мэргэжлийн боловсон хүчинтэй болж, цаашлаад химийн бодисын үйлдвэр барьж байгуулах эхлэлийг тавьж байна.

Мөн уг үйлдвэр ашиглалтад орсноор тэсрэх бодисын үйлдвэрлэлийн чанарыг оновчилж, тэсэлгээний ажлын үр дүнг сайжруулахад үнэ цэнтэй хувь нэмрээ оруулна.

Төслийн хүчин чадал

Эмульгаторын үйлдвэрийн хүчин чадлыг үйлдвэрийн технологи үйл ажиллагаа, Монгол улсын өмнөх жилүүдийн эмульгаторын хэрэглээ зэргүүдийг харгалзан 2500 тн/жил байна гэж үзсэн. Үйлдвэрийн хүчин чадлыг эмульгаторын төрлөөс хамааруулан дараах 8 төрөлд ангилан, жилд үйлдвэрлэх хэмжээ тус бүрээр авч үзээд MT27-U-11 эмульгатор 20 тн/жил, MT27-U-12 эмульгатор 30 тн/жил, MT27-O-11 эмульгатор 1200 тн/жил, MT27-O-12 эмульгатор 300 тн/жил, MT27-O-13 эмульгатор 496 тн/жил, MT27-O-14 эмульгатор 300 тн/жил, MT27-P-11 эмульгатор 70 тн/жил, MT27-P-12 эмульгатор 80 тн/жил байхаар төлөвлөсөн.



II. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүй:

Налайх дүүрэг нь газарзүйн байршлын хувьд Хэнтийн уулархаг мужид хамаарагдана. Геоморфологийн хувьд голын татмын дэвсгэр нутаг болох бөгөөд голын татмаар нэвчилт шүүрэлт ихтэй сийрэгдүү, элс сайр, сайрган, хайргархаг аллювийн хурдас зонхилно.

Цаг уур, уур амьсгал:

Уур амьсгалын үндсэн нөхцөл нь эх газрын эрс тэс цаг агаарын шинжтэй, хот орчмын бичил, бэсрэг уур амьсгалын онцлогтой. Налайх орчмын агаарын температур өвөл 18.80 - 22.70, зун 12.80 - 15.40, Жилд унах тунадасны хэмжээ 260-290 мм, жилийн дундаж агаарын даралт 852.3 гПа, дундаж салхины хурд жилд 4.2 м/с байна.

Гадаргын болон газар доорх ус:

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор орчимд гадаргын ус байхгүй. Налайх орчмын гидрогеологийн зурагт тэмдэглэснээр Налайхын нүүрсний уурхай орчимд Туул голын хөндийд газрын доорх устай аллювийн хурдас, Налайхын хотгорт их талбайд тархалттай, бага нөөцтэй газрын доорх устай доод цэрдийн хурдас, үндсэндээ усгүй неогений хурдас тус тус тархсан байна.

Хөрс, ургамал, амьтан:

Хөрс газарзүйн мужлалаар уулын хар хүрэн, хар шороон, уулын тайгын ширэгт, уулын ойн бараан хөрстэй Хэнтийн өмнөт тойрогт багтдаг. Үйлдвэр байрлаж буй газрын хэмжээнд хээрийн хөнгөн шавранцар хар хүрэн хөрс зонхилон тархана.

Ургамалжилтын ангиллаар Бага Хэнтийн уулархаг мужийн уулын хээр, нам толгодын хөндий, тал хээрийн бүсэд багтана. Налайхаас зүүн урагш Баянгийн овоо, Баян-Уул хүртэл уулын хээрийн хөнгөн шавранцар хөнгөн хөрстэй, жижиг үетэн-алаг өвст, чулуурхаг нам толгодоор үетэн-алаг өвст-үетэн-агьт бүлгэмдэл тааралдана. Налайх суурины орчим Хонхор нуур хүртэл нам толгодын бэл хөндийгөөр үетэн-агьт, үетэн-алаг өвс-шарилжит, үетэн шарилжит бүлгэмдэлтэй талхлагдсан бэлчээр зонхилно.

Амьтны аймгийн мужлалаар Хэнтийн тойрогт багтана. Налайх дүүрэг орчимд цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад багтана.

Нийгэм-эдийн засаг:

Налайх дүүрэг нь Засаг захиргааны 7 хороотой. 5 болон 6 дугаар хороод нь жуулчдыг татдаг байгалийн үзэсгэлэнт газар болох Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт байрладаг.

Монгол Улсын авто замын босоо болон хэвтээ тэнхлэгийн огтлолцолд оршдог, авто зам, төмөр зам, агаарын тээвэр хөгжсөн, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй, нийслэлийг цэвэр усаар хангаж байгаа дээд эх үүсвэртэй шууд холбогдсон, Монгол орны аялал жуулчлалын гол бүс нутаг хамаардаг, хүн амын дийлэнх олонхыг залуучууд болон хөдөлмөрийн насныхан эзэлдэг, түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт ихтэй зэрэг давуу тал олон.

III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 2-р хэсэгт тусгасны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан боловсруулав.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ЗОРИЛТ

“МЕРА” ХХК нь энгийн тэсрэх бодис, задгай болон савласан эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага түвшинд байлгахыг 2026 онд зорилт болгон ажиллаж байна.

- Монгол улсын Үндсэн хууль болон бусад байгаль орчинтой холбоотой хууль, дүрэм журам, стандартуудын хүрээнд үйл ажиллагаа явуулах.
- Байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглаж, үйл ажиллагаанаас бий болсон хоёрдогч түүхий эд, материалыг зүй зохистой ашиглах ба дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- Сум орон нутгийн байгууллагатай байгаль орчин нийгмийн хүрээнд хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг нээлттэй байлгах.
- “Байгаль орчны менежментийн тогтолцоо, шаардлага, хэрэглэх арга зүйн заавар MNS ISO 14001:2016” стандартын хэрэгжилтийн нийцтэй байдлын талаарх магадлах гадаад аудитыг хийлгэж, байгальд сөрөг нөлөөлөл багатай техник, технологиор үйл ажиллагаагаа явуулж, учирч болзошгүй эрсдэлүүдийг байнгын хяналтдаа байлгах.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний сайжруулалтыг хийж, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг тодорхойлох.
- Үйл ажиллагааны процессуудын эрсдэлийн тодорхойлж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.

Хүснэгт 2. Тухайн жилийн БОМТ нийт зардлын нэгтгэл

Дд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тухайн жилийн БОМТ-д төлөвлөсөн зардал /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5,200,000.00₮
2	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	500,000.00₮
3	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	7,400,000.00₮
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,400,000.00₮
5	Орчны хяналт шинжилгээний мониторинг	870,000.00₮
6	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээ	200,000.00₮
	НИЙТ ЗАРДАЛ	17,570,000.00

IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөсөн зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, шаардлага
Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах						
1	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол	Тэсэлгээний бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд, зориулалтын сав баглаа боодол, контейнерт хадгалах.	Төслийн барилга байгууламж	Үйл ажиллагааны зардлаар	2026 онд	MNS3113:1981 “Байгаль орчныг хамгаалах. Агаар бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага” MNS3384:1982 “Байгаль орчныг хамгаалах. Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага” MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS45852025 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” MNS6063-2010 “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS4990-2023 “ХААЭА. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
2		Ажлын байр, агуулах, автозасвар автограж зэрэг барилгуудын агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах,	Төслийн барилга байгууламж	₮ 500,000	2026 онд	
3		Үйлдвэрийн байрны дотоод орчны агаарын чанарыг хэмжих багаж суурьшуулах	Төслийн хэмжээнд	₮ 1,500,000	2026 онд	
4	Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2009 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2009 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон Олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлэх	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардал тусгах	Тогтмол	

5	Ашиглагдаж буй машин техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	
Нийт зардал: ₮2,000,000					

ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөсөн зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, шаардлага
1	Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах	Техникийн эвдрэл гэмтлийг зориулалтын талбай (засварын цех)-д байрлуулж засах	Үйлдвэрийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	Монгол улсын засгийн газрын 1995 оны 143-р тогтоолын 2 дугаар хавсралт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”-эзэмшил газрынхаа төлөв байдал, чанарын хянан баталгааг хийлгэх, MNS3297-2019
2	Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх. Тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	“Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”, MNS5850-2019
3	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдох	Засварын цех, ШТМ-ын агуулах, хуучин тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг цементлэх, цаашид засаж сайжруулж байх	Төслийн хэмжээнд	3,000,000	Тогтмол	“Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
4	Үйлдвэрийн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал, мөн хоолны үлдэгдэл, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт сар тутам зөөвөрлөн хаяж байх	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	
нийт зардал: ₮3,000,000						

УСАН ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ						
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төсөвлөсөн зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, шаардлага
1	Газрын доорх ус хомсдох	Төслийн, үйлдвэр болон агуулах орчмын үерийн хамгаалалт, даланд үзлэг шалгалт хийж, засварлаж байх	Төслийн талбайд	₮200,000	Тогтмол	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Шагах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн зэрэг бодис алдагдах, хур тунадас болон үерийн усаар угаагдан усан орчныг бохирдуулах	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2026 онд	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт MNS 5667-2:2001 Усны чанар, дээж авах арга
3	Үйлдвэр, ахуйн бохир ус алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид тушаах	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2026 онд	
Нийт зардал: ₮200,000						

V. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

	Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Үйл ажиллагааны зардалд тусгах	2026 он	ХАБЭА-ын мэргэжилтэн	ISO14001
2	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог	Үйл ажиллагааны	2026 он	ХАБЭА-ын мэргэжилтэн	Хог хаягдлын тухай хууль

	хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөглөх	зардалд тусгах			
3	БОАЖ-ын сайдын 2018 оны 02 дугаар сарын 02-ны А/21 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлан мэдээг гаргаж аймагт жил бүр хүргүүлнэ	Үйл ажиллагааны зардалд тусгах	2026 он	Байгаль орчны мэргэжилтэн	Хог хаягдлын тухай хууль
4	Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын удирдлага болон орон нутгийн онцгой байдлын газраар батлуулна	Үйл ажиллагааны зардалд тусгах	2026 он	Байгаль орчны мэргэжилтэн	Гамшгийн тухай хууль
5	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрэм боловсруулж, байгууллагын удирдлагаар батлуулж ажиллана	Үйл ажиллагааны зардалд тусгах	2026 он	ХАБЭА-н мэргэжилтэн	ХАБЭА-н тухай хууль
6	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 10 ¹ дүгээр зүйлийн 1-д заасны дагуу байгаль орчны аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгах	2026	Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Нийт зардал: ₮200,000					

VI. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Төлөвлөсөн зардал (төгрөг)	Баримтлах стандарт, шаардлага
1	Төсөл хэрэгжих газар байгаль, цаг уурын онцлогт тохируулан үйлдвэрийн хашаан дотор мод тарьж	Мод тарих /Хайлаас, буйлс, улиас/	Эзэмшлийн газрын талбайд 200ш мод тарих	Үрсэлгээ /Суулгацын тоо/	₮ 500,000	Эвдэрсэн газрын ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008

ногоон байгууламжийг өргөтгөх байгуулах					Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл
---	--	--	--	--	---

VII. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, шаардлага
Болзошгүй осол						
1	Газар хөдлөлт	Орон нутгаас зохион байгуулах газар хөдлөлийн аюулын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр болон турших дасгал сургуулилалтад ажилчдыг хамруулах	Төслийн талбай	200,000.00	Жилд 1 удаа	ГАМШГИЙН ТУХАЙ ХУУЛЬ
2	Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг өндөрлөг газруудад суурилуулах. цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбай	2,500,000.00	Төсөл эхлэхэд	ГАМШГИЙН ТУХАЙ ХУУЛЬ
3	Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилтнуудыг химийн бодисын хор аюул, түүнтэй хэрхэн харьцах, асгарч, алдагдсан үед авах арга хэмжээ, хувийн хамгаалах хэрэгсэл, анхны тусламж, галын аюулын үед авах арга хэмжээний талаар сургалтад хамруулах	Үйлдвэрийн ажилчид	400,000.00	Жилд 1 удаа	Химийн бодисын тухай хууль
4		Анхны тусламжийн эмийн сан байршуулах	Үйлдвэрийн объект бүрд	500,000.00	Тогтмол бүрэн бүтэн байдлыг хангах	MNS 5029:2011 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ.
5	Осол, аварга	Ажилчдын ажлын байрны нөхцөлтэй нь уялдуулан аюулгүй ажиллагааны, хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	Үйлдвэрийн объект бүрд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль:

6		Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах	Үйлдвэрийн объект бүрд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль:
7		Дархлаа дэмжих, хор саармагжуулах эрүүл ахуйн шаардлага бүтээгдэхүүнээр хангах	Үйлдвэрийн объект бүрд	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль:
8	Гал түймэр	Гал гарч болзошгүй объектуудын ойролцоо ил гал гаргах, тамхи татахыг хатуу хориглох, самбар байршуулах	Үйлдвэрийн объект бүрд	400,000.00	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль
9		Болзошгүй галын аюулын үед ашиглах гал унтраах хэрэгсэл, материалыг шаардлагатай газар бэлэн байлгах	Үйлдвэрийн объект бүрд	400,000.00	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль
10		Утаа мэдрэгч, автомат гал унтраагуур байршуулах	Үйлдвэрийн объект бүрд	500,000.00	Тогтмол	Галын аюулгүй байдлын тухай хууль
11	Химийн бодис нурах, асгарах	Битүү болон задгай агуулахын шалыг зай завсаргүй бетондсон байх, химийн бодист тэсвэртэй эпокси будгаар будах	Төслийн хүрээнд	2,500,000.00		
Нийт зардал: ₮ 7,400,000.00						

VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төсөвлөсөн зардал (төгрөг)	Баримтлах стандарт, шаардлага
1	Ахуйн	Хог хаягдал түр хадгалах цэгийг цементээр хучих болон хашаа хамгаалалт хийх	Хогийн цэг	1,000,000	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дугаар сарын 09-ны өдрийн А-116 дугаар тушаалын хавсралт “Хог хаягдлын тухай” хууль 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 15 дугаар зүйл, 40 дүгээр зүйл MNS 5850:2019 MNS 5344 : 2011 MNS ISO 11074-1 : 2001
2		Ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын цэгт нийлүүлэх (тээвэрлэх)	Төслийн хүрээнд	1,000,000	
3		Ангилан хаях зориулалттай хогийн савыг үйлдвэрт байрлуулах	Төслийн хүрээнд	1,000,000	
4	Үйлдвэрийн	Шатах тослох материалын хаягдал зориулалтын саванд цуглуулж, хадгалах	Төслийн орчим	Үйл ажиллагааны зардалд тусгах	

5		Техникийн хог хаягдлыг хадгалах цэг байгуулах, эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардалд тусгах	
6		Төмрийн хог хаягдлыг хаягдал төмөр авах цэгт нийлүүлэх	Төслийн хүрээнд	400,000	
7	Аюултай	Химийн бодисын сав баглаа боодол устгах гэрээ хийх	Төслийн хүрээнд Гэрээний дагуу	Үйл ажиллагааны зардалд тусгах	
Нийт зардал: ₮3,400,000					

IX. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Төлөвлөсөн зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, шаардлага
1	Хөрсний хүнд металлын үзүүлэлтээр	Үйлдвэр, агуулах орчмын хөрсний 2 цэг	Жилд хоёр удаа	2	₮ 200,000	Төслийн талбайн хөрс бохирдуулагч бодисууд болон хүнд металлын хэмжээг тодорхойлох	MNS 5850:20198 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Агаар орчны шинжилгээ	Үйлдвэр, агуулах орчмын агаарын 2 цэг	Жилд хоёр удаа	2	₮ 470,000	Төслийн талбайн агаар дахь бохирдуулагч, дуу чимээний хэмжээг тодорхойлох.	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
3	Усны химийн шинжилгээ	Унд ахуйн усанд	Жилд хоёр удаа	2	₮ 200,000		
Нийт зардал: ₮ 870,000							

**Х. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ,
СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	БОУАӨЯам, Хүрээлэн буй орчны Бодлого зохицуулалт ын газарт	Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган БОУАӨЯам-нд хүргүүлнэ.	БОМТ-ний хэрэгжилтийн тайлан гүйцэтгэл	Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор илгээх	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хүлээн авч дүгнэлт гаргаж, дараагийн жилд хэрэгжүүлэх БОМТ-г хянан батална.	БО-ны мэргэжилтэн	“МЭРЭ” ХХК
2	Төсөл хэрэгжих сумын засаг дарга, Багийн засаг дарга	Хагас жилийн тайланг хүргүүлж санал авах	Төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн ажлуудын мэдээлэл	Хагас жил тутам	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилт	Салбарын менежер	
3	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн Байгаль орчны хяналтын улсын байцаагч						
4	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн багийн ИНХ	Танилцуулга хийх	БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулга	Хагас жил тутам	БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулж, санал авах	Салбарын менежер, БО мэргэжилтэн	
5	Иргэд, олон нийт/ дурын оролцогч, сонирхогч талууд	Санал хүсэлт хүлээн авч, төсөлтэй холбогдох гомдлыг шийдвэрлэж, барагдуулах	МЭРЭ ХХК-ийн үйл ажиллагаа, БО хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэж буй ажил, орон нутгийн хамтын ажиллагааны талаар	Төсөл хэрэгжих бүхий л хугацаанд	Сонирхогч, оролцогч талуудыг хүссэн мэдээллээр хангах	Салбарын менежер	

